



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/543

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтын 4.10.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Боловсролын сайдын багцаас хэрэгжсэн “Ньюсоник” ХХК-ийн гүйцэтгэсэн Боловсролын салбарын тоног төхөөрөмж (Ховд), 2 дугаар багц ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Л.Батгэрэл (Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд: Б.Даваажаргал (Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Сонинтуяа (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Н.Даваажаргал (Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Г.Төмөрсүх (Боловсрол, шинжлэх ухааны газрын нярав)

Д.Анхбаяр (“Ньюсоник” ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн

дарга: Б.Уугантуяа (Боловсрол, шинжлэх ухааны газрын Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн)

2. Тус ажлыг захиалагчаас баталсан ажлын даалгаврын дагуу шалгаж, хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Батгэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Х.БАТБОЛД

84000011000

Zah A/543/KH